



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/372

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх олгох,  
сунгах, хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Сайнцагаан сумын Хөүмланд, Өргөн-Ундраа, Сүлд-Оюу хайрхан, Эрдэнэдалай сумын Содбилэгдалай ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацаагаар сунгасугай.

2. Сайнцагаан сумын Арвин их сан, Хулд сумын Хулд хармагтай ХХК-ний хүнсний дэлгүүрт архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

3. Сайнцагаан сумын татварын албанд бүртгэлтэй Мандал дэнж ХХК-ны хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс хүчингүй болгосугай.

4. Хөүмланд, Өргөн-Ундраа, Сүлд-Оюу хайрхан, Арвин их сан ХХК-ны хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08<sup>00</sup> -24<sup>00</sup>, Содбилэг далай, Хулд хармагтай ХХК-ны хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09<sup>00</sup>-21<sup>00</sup> цаг хүртэлх хугацаагаар тус тус баталсугай.

5. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ